


Аюулгүй ажлалааг эрхэллэж, байгаль орчинд ээлтэй, дэвшилтэт технологи ашиглан ЦЭХ-ийг
найдвартай, үр ашигтай дамжуулах нь бидний эрхэн зорилго мөн.



ДАМЖУУЛАХ

Сүлжээ



2005 оноос эрхлэн гаргав.

ЦДҮС ТӨХК-ИЙН ХЭВЛЭЛ
www.transco.mn

ТӨРИЙН ДЭЭД ОДОН МЕДАЛИАР ШАГНУУЛАВ

№01 (159) 2024 оны 02 сар



XVII жарны “Хилэнт эх” хэмээх модон луу жилийн сар шинийн баярыг тохиолдуулан Эрчим хүчний дэд сайд М.Баярмагнай, Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Тавинбэх нар амжилт хөдөлмөрөөрөө манлайлсан салбарын хамт олондоо төрийн дээд одон, медаль гардууллаа. Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонгоор ахмад настан Оргийн Алтанцэцэг, хөдөлмөрийн хүндэт медалиар Улаанбаатар салбарын ашиглалт, шуурхай үйлчилгээний албаны дарга Зандангийн Өлзийбаяр нар тус тус шагнуулж, хөдөлмөр зүтгэлээ төр түмэндээ үнэлүүлсэн юм. Төрийн дээд одон медалиар энгэрээ мялаасан О.Алтанцэцэг, З.Өлзийбаяр нартаа компанийн хамт олны нэрийн өмнөөс халуун баяр хүргэж, ажлын амжилт, сайн сайхан бүхнийг хүсье!



НҮҮР-3

ТӨВ УДИРДЛАГЫН САР
ШИНИЙН НЭГДСЭН
ЗОЛГОЛТЫГ
ЗОХИОН БАЙГУУЛАВ

НҮҮР-5

УЛААНБААТАР САЛБАР

НҮҮР-7


ХАНГАЙН БҮСИЙН
САЛБАР

НҮҮР-9

ГОВИЙН БҮСИЙН
САЛБАР

НҮҮР-11

ГОВИЙН БҮСИЙН
САЛБАРЫН ЕРӨНХИЙ
ИНЖЕНЕРЭЭР
ТОМИЛОГДЛОО



ТӨВ УДИРДЛАГЫН АЖИЛТНУУДЫН СПОРТЫН 7 ТӨРӨЛТ ТЭМЦЭЭН БОЛЛОО



“Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК-ийн төв удирдлагын ажилтнуудын дунд спортын 7 төрөлт тэмцээн 2023 оны 22-26-ны өдрүүдэд болж өнгөрлөө. Өмнөх жилүүдэд 5 төрлөөр зохион байгуулагдаж ирсэн тус тэмцээнд боулинг, биллиардын төрлийг нэмснээс гадна бүх ажилчдыг 6 багт ижил хувааж, тэгш оролцоог бий болгосон нь энэ удаагийн тэмцээний онцлог байв.

Сагсан бөмбөгийн эрэгтэй ангилалд

- Тэргүүн байрыг IV баг
- Дэд байрыг VI баг,

Сагсан бөмбөгийн эмэгтэй ангилалд

- Тэргүүн байрыг III,IV багаас бүрдсэн холимог баг
- Дэд байрыг V,VI багаас бүрдсэн холимог баг

Воллейболын эрэгтэй ангилалд

- Тэргүүн байрыг II баг
- Дэд байрыг I баг

Воллейболын эмэгтэй ангилалд

- Тэргүүн байрыг III,IV багаас бүрдсэн холимог баг
- Дэд байрыг I, II багаас бүрдсэн холимог баг

Шатрын төрөлд

- Тэргүүн байрыг II баг
- Дэд байрыг V баг

Ширээний теннисний төрөлд

- Тэргүүн байрыг IV баг
- Дэд байрыг II баг

Дартсын төрөлд

- Тэргүүн байрыг I баг
- Дэд байрыг IV баг

Боулингийн төрөлд

- Тэргүүн байрыг V баг
- Дэд байрыг IV баг

Биллиардын төрөлд

- Тэргүүн байрыг IV баг
- Дэд байрыг V баг


Багийн нийт дүнгээр IV баг тэргүүлж, дэд байрыг II баг эзэлж, V баг удаалсан бол ерөнхий шүүгчийн саналаар I-р баг тусгай байрт шалгарсан юм. Тус тэмцээний “Шилдэг хөгжөөн дэмжигч” багаар IV багийн хамт олон тодорч, бусад багийн хөгжөөн дэмжигчдийг хошуучиллаа. Энэхүү тэмцээнд идэвх санаачилгатай оролцсон ажилтан, албан хаагчид болон амжилт гаргасан баг тамирчиддаа ажлын амжилт хүсье!



ТӨВ УДИРДЛАГЫН САР ШИНИЙН НЭГДСЭН ЗОЛГОЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛАВ

“ Төв удирдлагын сар шинийн золголтыг 2024.02.13-ны өдөр буюу шинийн дөрвөнд зохион байгуулав. Нэгдсэн золголд төв удирдлагын ахмад настан Аж үйлдвэрийн гавьяат ажилтан Л.Дарамбазар, Д.Зоригт, Д.Жанчив, Г.Цэцгээ нар оролцлоо.






ТӨВ УДИРДЛАГА

“OBSERVE STAR” КОМПАНИ “ХӨДӨЛМӨРИЙН ЭРҮҮЛ МЭНД, АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ УДИРДЛАГЫН ТОГТОЛЦОО ISO 45001:2018 СТАНДАРТ”-ЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТАНИЛЦУУЛГА СУРГАЛТ ХИЙВ

Ажилтнуудын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаарх ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх, стандарт, шаардлага хангасан эрүүл, аюулгүй ажлын байрыг бүрдүүлэх, аливаа болзошгүй ослоос өөрийгөө болон бусдыг урьдчилан сэргийлэх соёл, хандлагыг төлөвшүүлэх ажлын хүрээнд Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны ISO45001:2018 стандартыг компанийн хэмжээнд нэвтрүүлэхээр үе шаттайгаар ажиллаж байна. Энэхүү ажлын хүрээнд

тус стандартыг компанийн төв удирдлага болон Улаанбаатар салбарт хэрэгжүүлэх OBSERVE STAR ХХК-ийн ХЭМАБ-ын зөвлөх, сургагч багш, тэргүүлэх аудитор Ж.Дэлгэрцэцэг, ХЭМАБ-ын зөвлөх Н.Тунгалаг нар 2024 оны хоёрдугаар сарын 20-ны өдөр ирж компанийн удирдлагуудад OBSERVE STAR ХХК-ийн танилцуулга, ISO45001:2018 стандартыг хэрэгжүүлэх зөвлөх үйлчилгээний талаар сургалт явууллаа.




СУРГАЛТАД ХАМРАГДАВ

"Тогоо тохируулъя" нөлөөллийн аяны хүрээнд ЭХЗХ, USAID ТББ хамтран сэтгүүлч, эрчим хүчний салбарын хэвлэл мэдээллийн мэргэжилтнүүдэд салбарын талаарх ойлголт мэдлэг олгох, эрчим хүчний хэмнэлт хийх хэрэгцээ шаардлагыг таниулах, эрчим хүчний сэдвээр сэтгүүлчдийн болон мэргэжилтнүүдийн бичих ур чадвар, туршлагыг нэмэгдүүлэх зорилгоор 2024 оны 1-р сарын 4-24-ний өдрийг хүртэл 4 удаагийн сургалт зохион байгуулав. Тус сургалтад УБЦТС, ЦДҮС, тэргүүтэй эрчим хүчний үйлдвэр компаниудын хэвлэл мэдээлэл хариуцсан мэргэжилтнүүд хамрагдаж, санал солилцлоо.



Мэдээллийг бэлтгэсэн: ЗУХ-ийн хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах мэргэжилтэн Д.Энхбаяр



УЛААНБААТАР САЛБАР

ХАБЗА ЧИГЛЭЛЭЭР ХИЙГДСЭН АЖИЛ

Ээлжит шалгалт зохион байгуулав

ЦДҮС ТӨХК-ийн Улаанбаатар салбарын нийт ажилтнуудын 2024 оны ээлжит мэдлэгийн шалгалт авах ажлыг зохион байгуулав. Шалгалтыг Туул дэд станцын сургалтын танхимд Улаанбаатар салбарын мэдлэгийн шалгалтын комисс зохион байгуулсан бөгөөд компьютерын программ болон бичгээр гэсэн хосолсон хэлбэрээр авсан. Ээлжит мэдлэгийн шалгалтад давхардсан тоогоор нийт 577 ажилтан хамрагдсан.




Ажилтнуудын ээлжит мэдлэгийн шалгалтын үеэр

Галын аюулаас урьдчилан сэргийлэх чиглэлээр

Баянгол дүүргийн нутаг дэвсгэрт байрлах Баруун, Дундгол дэд станцууд болон салбарын байрны "Гал унтраах шуурхай төлөвлөгөө"-г боловсруулж, Баянгол дүүргийн Онцгой байдлын хэлтсийн гал унтраах ангийн захирагчаар батлуулсан.

Хамгаалалтын зурвас

220 кВ-ын 211, 212 дугаар агаарын шугамын хамгаалалтын зурвас зөрчилтэй Дашваанжил газр ХХК, NCD перкон ХХК, Монцемент ХХК, MGL цемент ХХК, Ойн бирж ХХК-уудад албан мэдэгдэл хүргүүлсэн.



Ээлжит болон ээлжит бус сургалтууд

Ээлжит сургалтын хөтөлбөрийн дагуу 2023.01.10-11-ний өдрүүдэд УБЦТС ТӨХК-ийн хурлын зааланд онолын сургалтыг зохион байгуулж, нийт 339 ажилтан хамрагдсан.



Сургалтын явц

Ашиглалт, шуурхай үйлчилгээний албаны 8 хэсгийн ажлын байрны сургалтыг 2024.01.09,10,15,16,17-ны өдрүүдэд Туул дэд станцын сургалтын танхимд зохион байгуулсан. Сургалтыг Ашиглалт, шуурхай үйлчилгээний албаны ахлах бөгөөд диспетчер инженер З.Наранзул, ээлжийн инженер Н.Мягмарсүрэн, диспетчер инженерүүд болон дэд станцын ашиглалтын инженерүүд заав. Сургалтад нийт 240 ажилтан хамрагдсан.



Сургалтын явц


Засварын албаны ажлын байрны 2024.01.24-26-ны өдрүүдэд Засварын албаны ажлын байранд зохион байгуулав. Сургалтыг Засварын албаны дарга В.Мөнхбат, ахлах бөгөөд засварын инженер В.Батбаяр, шугамын засварын инженер М.Мөнгөн-Эрдэнэ, дэд станцын засварын мастер Б.Буяннэмэх, шугамын засварын мастер Д.Ууганбаяр нар заав.



ШУТИС ЭХС-ийн багш доктор, профессор (P.Dh) Г.Бэхбатыг урьж, 2024.01.25-ны өдөр SF6, CF4 хийг шахах солих технологи, хадгалалт, хамгаалалт, хийг цэвэрлэх аргачлал, ашиглалтын үеийн чанарын үзүүлэлт, түүнийг хэмжих, хийн аж ахуйн тухай сургалт зохион байгуулав. Сургалтад Инженерийн алба, Засварын албаны ажилтнууд, Ашиглалт, шуурхай ажиллагааны албаны дэд санцын ашиглалтын инженерүүд хамрагдсан.



Реле хамгаалалт автоматик, хэмжилт, туршилтын албаны ажлын байрны дотоод сургалтыг 2024.01.22,23-ны өдрүүдэд ажлын байранд нь зохион байгуулсан. Сургалтыг Нийлмэл реле хамгаалалт автоматикийн инженер Б.Тогтохжаргал, Х.Билгүүнбат, Ц.Балдандорж, реле хамгаалалт автоматикийн инженер Б.Идэрбат, өндөр хүчдэлийн туршилтын инженер Р.Ууганбаатар нар заав.



А3 сертификат олгох сургалт

Төв удирдлагаас 2024.01.17-ны өдөр зохион байгуулсан худалдан авах ажиллагааны А3 сургалтад салбарын 11 ажилтныг цахимаар хамруулсан.


Эрчим хүчний салбарын хууль эрх зүйн сургалт

Эрчим хүчний яам, Эрчим хүчний үндэсний төвийн Сургалт үйлдвэрлэлийн төвтэй хамтран зохион байгуулсан "Эрчим хүчний салбарын хууль эрх зүйн орчны тухай" сургалтад Захиргаа, аж ахуйн албаны хуулийн зөвлөх М.Мөнхчимэг, гэрээ, аж ахуй хариуцсан мэргэжилтэн Ц.Нарантуяа нарыг танхимаар бусад ажилтнуудыг цахимаар хамруулсан.



АШИГЛАЛТЫН ТҮВШИН, НАЙДВАРТАЙ АЖИЛЛАГААГ ДЭЭШЛҮҮЛЭХ ТАЛААР

2024 оны 02-р сарын 07, 08-ны өдрүүдэд 110/10 кВ-ын Илчбаян дэд станцын Т-1,2 трансформатор, 110 кВ-ын I, II СШ-н 12 ком салгуур, 5 ком таслуур, 6 ком гүйдлийн трансформатор, 4 ком хүчдэлийн трансформатор, 4 ком цэнэг шавхагчийн тусгаарлагчийн бохирдлыг цэвэрлэж, салгуурын тохиргоог шалгаж, шаардлагатай засвар үйлчилгээг хийж гүйцэтгэсэн.



1-р СШ-н урсгал засварын ажил



2-р СШ-н урсгал засварын ажил



Корпус хугарсан байдал

БУСАД АЖЛААР

Спортын тэмцээн зохион байгуулав

Улаанбаатар салбарын аварга шалгаруулах спортын тэмцээнийг 2024 оны 01 дүгээр сарын 18-21-ний өдрүүдэд нийт ажилтнуудын дунд амжилттай зохион байгуулж, дартс, ширээний теннис, шатар, гар бөмбөг, сагсан бөмбөг гэсэн таван төрөлд аваргуудаа тодруулав. Үүнд:

Дартсын төрөлд /эмэгтэй/:

1-р байр Засварын албаны техникч Х.Дагисүрэн

2-р байр Инженерийн албаны ахлах бөгөөд ашиглалтын инженер Б.Нарантуяа

3-р байр Инженерийн албаны мэдээллийн технологи, компьютерын инженер Д.Ган-Отгон

Дартсын төрөлд /эрэгтэй/:

1-р байр Засварын албаны шугамын засварын монтер С.Сэргэлэн

2-р байр Захиргаа, аж ахуйн албаны хангамжийн мэргэжилтэн Б.Эрдэнэ-Оргил

3-р байр Засварын албаны шугамын засварын монтер Н.Мөнхцогт

Шатрын төрөлд /эмэгтэй/:

1-р байр Реле хамгаалалт автоматик, хэмжилт, туршилтын албаны реле хамгаалалт автоматикийн инженер Э.Одбал

2-р байр Ашиглалт, шуурхай үйлчилгээний албаны ээлжийн монтер Ц.Буянхишиг

3-р байр Санхүү, эдийн засгийн албаны эдийн засагч Ц.Сувдмаа

Шатрын төрөлд /эрэгтэй/:

1-р байр Ашиглалт, шуурхай үйлчилгээний албаны ээлжийн инженер Л.Хасбаатар

2-р байр Ашиглалт, шуурхай үйлчилгээний

албаны ээлжийн инженер Э.Төгөлдөр

3-р байр Ашиглалт, шуурхай үйлчилгээний албаны ээлжийн инженер Б.Батбаяр

Ширээний теннисний төрөлд /эмэгтэй/:

1-р байр Ашиглалт, шуурхай үйлчилгээний албаны ээлжийн монтер Б.Болортуул

2-р байр Ашиглалт, шуурхай үйлчилгээний албаны ээлжийн монтер Б.Эрдэнэзаяа

3-р байр Санхүү, эдийн засгийн албаны нярав Д.Амарзаяа

Ширээний теннисний төрөлд /эрэгтэй/:

1-р байр Ашиглалт, шуурхай үйлчилгээний албаны ээлжийн инженер Б.Энх-Амгалан

2-р байр Инженерийн албаны дарга М.Ганзориг

3-р байр Засварын албаны дэд станцын засварын монтер Ц.Баасанжав

Сагсан бөмбөгийн төрөлд /эмэгтэй/:

1-р байр Ашиглалт, шуурхай үйлчилгээний албаны 1-р баг

2-р байр Санхүү, эдийн засгийн алба

3-р байр Ашиглалт, шуурхай үйлчилгээний албаны 2-р баг

Сагсан бөмбөгийн төрөлд /эрэгтэй/:

1-р байр Реле хамгаалалт автоматик, хэмжилт, туршилтын алба

2-р байр Засварын алба

3-р байр Ашиглалт, шуурхай үйлчилгээний албаны 2-р баг

Гар бөмбөгийн төрөлд /эмэгтэй/:

1-р байр Ашиглалт, шуурхай үйлчилгээний албаны 1-р баг

2-р байр Санхүү, эдийн засгийн алба

3-р байр Холимог баг

Гар бөмбөгийн төрөлд /эрэгтэй/:


1-р байр Засварын алба

2-р байр Реле хамгаалалт автоматик, хэмжилт, туршилтын алба

3-р байр Ашиглалт, шуурхай үйлчилгээний албаны 2-р баг



Мэдээллийг бэлтгэсэн: УБС-ын ЗААА-ны ахлах бөгөөд дотоод ажил хариуцсан мэргэжилтэн Т.Аюуш



ТӨВИЙН БҮСИЙН САЛБАР

ХАБЭА ЧИГЛЭЛЭЭР ХИЙГДСЭН АЖИЛ

ХАБЭА-н тухай хуулийн 27.3.4, 28.1.8 заалт, МУ-ын ХНХ-ын сайдын 2019.12.13-ны өдрийн А/370 тоот ХАБЭА сургалт явуулах, шалгалт авах журмын 2.3 заалтыг үндэслэн 2024 оны 01 дүгээр сарын 05-ны өдөр ДУА-ийн ҮЭХ-ны дэргэдэх "Зөв Хөтөч" ТББ-тай хамтран ХАБЭА-н тухай хууль, ажлын байрны аюул эрсдэл, сөрөг хүчин зүйл, хөдөлмөрийн эрүүл мэнд, анхны тусламж сэдвээр нийт 8 цагийн сургалт зохион байгууллаа. Сургалтад танхимаар 96, цахимаар 80 ажилтан хамрагдсан.



Салбарын хэмжээнд 2024 оны 01 дүгээр сарын 10-ны өдрөөс эхлэн 2024 оны 02 дугаар сарын 21-ний өдрийг дуустал нийт 41 хоног үргэлжлэн 2024 оны ээлжит шалгалт явагдлаа. Шалгалт өгвөл зохих нийт 169 ажилтан бүрэн хамрагдаж дундаж үнэлгээ ААД - 81 %, ТАД - 85 %-тай амжилт үзүүлээ.




Ээлжит шалгалт аман хэлбэрээр явагдсан ба ААД-ийн хүрээнд ХАБЭА-н тухай хууль, ЦДҮС ТӨХК-ийн дотоод журам, ЭХАДЗ аюулгүй ажиллагааны ажлын үндсэн дүрэм, ХАБЭА-н чиглэлээр зохион байгуулдаг ажлууд, аюулгүй ажиллагааны дүрмийн холбогдох заалтууд, галын аюулаас урьдчилан сэргийлэх чиглэлээр, ТАД-ийн хүрээнд ажлын байран дээр тоноглолын ашиглалт, РХА-ын ажиллагаа, НСД, СЗЗЭ, цахилгаан байгууламжийн ашиглалтын үед мөрдөх техник ашиглалтын дүрмийн холбогдох заалтууд, сэлгэн залгалтын хуудас бичүүлэх зэрэг агуулга тус бүрээр үнэлгээ өгч дүгнэлээ.

АШИГЛАЛТЫН ТҮВШИН, НАЙДВАРТАЙ АЖИЛЛАГААГ ДЭЭШЛҮҮЛЭХ ТАЛААР

А. ТӨЛӨВЛӨГӨӨТ АЖИЛ:

1. 220 кВ-ын 257, 258, 110 кВ-ын Сүхбаатар, Дархан, 113, Үйлдвэр А.Б -агаарын шугамуудын нийт уртад баярын өмнөх ээлжит үзлэг хийсэн. Үзлэгээр 257, 258-р АШ-нд а/троссын ч/намжаагч гүйсэн, ш/үүртэй, 1ш элемент хагархай, 113-р АШ-нд 1ш элемент хагархай, Үйлдвэр А Б-АШ-нд ч/намжаагчийн бортог унасан, Дархан, Сүхбаатар АШ-нд 2ш элемент хагархай, утас чангаралттай, а/троссын ч/намжаагч гүйсэн зэрэг гэмтэл зөрчил илэрсэн. Тасралтад нөлөөлөх гэмтэл илрээгүй учир 2024 оны УЗ-аар төлөвлөгөөнд тусгасан.



2. Их засварын ажлын хүрээнд 220 кВ-ын 208-р АШ-ын Т№310-305 хооронд намгийн хамгаалалт хийх ажлын маршрутыг гаргаж гүйцэтгэгч байгууллагад зам талбай болон ажлын эзлэхүүнийг танилцуулсан, 5 тулгуурт чулуу хайрга овоолж намгийн хамгаалалт хийгдсэн.




3. Засварын багаж хэрэгсэлд үзлэг шалгалт хийж илэрсэн 20 зөрчил буюу ашиглалтын түвшин сайжруулах багаж хэрэгсэл завсарлах жагсаалтын дагуу засварын бэлтгэл хангах ажлын төлөвлөгөөг 25 нэр төрлөөр гаргаж биелэлт 53 хувьтай хийгдэж байна.



Б. ТӨЛӨВЛӨГӨӨТ БУС АЖИЛ БОЛОН ГЭМТЭЛ УСТГАЛТЫН АЖИЛ

1. 110 кВ-ын Хөтөл-А, Б агаарын шугамын үерийн усанд автсан Т№ 16, 17 намгийн хамгаалалт хийх ажлыг мастер Б.Саранболдын бригад хаалт бэлтгэн хийж чулуугаар дүүргэлт хийсэн.



БУСАД АЖЛААР

ЦДҮС ТӨХК Төвийн бүсийн салбарын 60 жилийн ойг угтсан спортын бага наадмыг сагсан бөмбөг, гар бөмбөг, ширээний теннис, шатар, дартс гэсэн 5 төрлөөр РХАХТА, СЭЗА-ны хамт олон 2024.01.24-2024.01.27-ны өдрүүдэд амжилттай зохион байгуулав.



Тэмцээн зохион байгуулалтын ажлын хүрээнд 5 төрөлт тэмцээний алт, мөнгө, хүрэл нийт 114 ширхэг медалиудыг РХАХТА-ны монтерүүд өөрсдийн нөөц бололцоог ашиглан хийв. Мөн тэмцээний хөтөлбөрийн дагуу тамирчдын ур чадварын тэмцээнд ашиглагдах байг хийсэн юм.



Энэ удаагийн тэмцээнд ахмад эмэгтэй баг тамирчид сагсан бөмбөг, гар бөмбөг, ширээний теннис, шатарын төрөлд оролцсон нь өмнөх жилүүдийн спортын тэмцээнүүдээс онцлогтой байлаа.



1-р байр Транзит баг

3-р байр АШҮА



2-р байр РХАХТА

Тэмцээний нийлбэр дүнгээр:

1-р байранд Транзит баг

2-р байранд РХАХТА-ны баг

3-р байранд АШҮА-ны багийн хамт олон шалгарав.


ЦДҮС ТӨХК-ИЙН ҮЙЛДВЭР ТЕХНИКИЙН ЗӨВЛӨЛИЙН I УЛИРЛЫН ХУРАЛ

ЦДҮС ТӨХК-ийн үйлдвэр техникийн зөвлөлийн I улирлын хурал Төвийн бүсийн салбарт амжилттай болж өндөрлөлөө. Үйлдвэр техникийн хуралд төв компани болон 5 салбар, хэлтэс оролцож хөтөлбөрийн дагуу асуудлуудыг хэлэлцлээ.



ЦДҮС ТӨХК-ийн үйлдвэр техникийн зөвлөлийн I улирлын хуралд оролцогчид төвийн бүсийн салбарын конторт "Power scada" болон тоолуурын мэдээллийн системтэй танилцлаа.

Мэдээллийг бэлтгэсэн: ТБС-ын ЗААА-ны бичиг хэрэг, архивч Д.Даваасүрэн



ХАНГАЙН БҮСИЙН САЛБАР

ХАБЭА ЧИГЛЭЛЭЭР ХИЙГДСЭН АЖИЛ

Ээлжит шалгалт: 2024 оны ажилтнуудын ээлжит шалгалтыг 01 дүгээр сарын 22-оос 02 дугаар сарын 02-ны өдрүүдэд зохион байгуулж, нийт 145 ажилтан өгснөөс 35 ажилтан хангалтгүй дүн үзүүлж, давтан шалгалт өгсөн. Салбарын хэмжээнд шинээр ажилд орсон болон ажлын байр өөрчлөгдсөн ажилтнуудаас дагалдан суралцах программын дагуу шалгалтын комисс тухай бүр шалгалт авч 7 ажилтныг жинхлүүлэн, 5 ажилтанд шинээр групп олгон, 2 ажилтны группийг ахиулсан байна.



Наряд, шийдвэрээр хийгдсэн ажил: Салбарын харьяа нийт 12 дэд станцын тоног төхөөрөмжүүд болон 110кВ, 220кВ-ын ЦДАШ-уудад нарыдаар 29, шийдвэрээр 91 удаагийн ажил гүйцэтгэж, зөрчил дутагдалгүй ажиллалаа.

Ажил гүйцэтгэх бригадуудын нийт 512 ажилтанд тухайлсан зааварчилгааг өгч ажилласан байна.

Дасгал, зааварчилгааны талаар: Шинээр ажилд орсон 4 ажилтанд урьдчилсан зааварчилгаа, 7 ажилтанд ажлын байрны анхан шатны зааварчилгаа, 3126 ажилтанд өдөр тутмын зааварчилгаа, 291 ажилтанд сар бүрийн ээлжит зааварчилгаа, ээлжит бус зааварчилгааг 327 ажилтанд тус тус өгч ажилласан байна.

Салбарын алба, хэсэг, дэд станцууд дээр аваар эсэргүүцэх дасгал 8 удаа хийгдэж нийт 107 ажилтан, гал эсэргүүцэх дасгал 5 удаа хийгдэж нийт 72 ажилтан, осол эсэргүүцэх дасгал 6 удаа хийгдэж нийт 64 ажилтан тус тус хамрагдсан байна.



ХАБЭА-н бүх шатны үзлэг: Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн анхан шатны үзлэгийг давхардсан тоогоор 78 удаа хийж 136 зөрчил, II шатны үзлэгийг 17 удаа хийж 57 нэрийн зөрчил, III шатны үзлэгийг 9 удаа хийж 49 зөрчлийг илрүүлэн нийтдээ 202 зөрчил дутагдлыг арилгах арга хэмжээг авч ажилласан.

2024 оны 01 дүгээр сарын 22-30-ны өдрүүдэд Хишиг-Өндөр, Сансар, Хархорин, Цэцэрлэг, Арвайхээр, Баянтээг, Баянхонгор,


Тосонцэнгэл дэд станцуудад ХАБЭА-н III шатны үзлэг шалгалт хийж, илэрсэн зөрчлүүдийг устгах хугацаатай даалгавар өглөө.

БУСАД АЖЛААР

Өндөржүүлсэн бэлэн байдал болон Сар шинийн баярын өдрүүдэд ажилласан хариуцлагатай жижүүрийн тайланг нь ХМХ, ШЗХ-т хүргүүлсэн.


Компанийн ерөнхий инженерийн 02/1646 албан тоот хэвийн ажиллагаа алдагдахаас урьдчилан сэргийлж, үзлэг шалгалт зохион байгуулсан ажлын тайланг сар бүрийн 15-ны өдөр ХМХ-т хүргүүлж ажиллаж байна.

Сургалтын талаар: 2024 оны ээлжит сургалтыг 2024 оны 01 дүгээр сарын 10-12-ны өдрүүдэд Орхон аймагт танхим болон цахим хэлбэрээр зохион байгуулсан. Нийт 3 хоногийн 24 цагийн сургалтад давхардсан тоогоор танхимаар 928 ажилтан цахимаар 778 ажилтан хамрагдсан байна.



Засварын ажил эхлэхтэй холбогдуулан тусгай тоноглолын машин механизмын оператор, аюулгүй ажиллагаа хариуцагч, оосорлогч дохиочны эрх сунгах, авах

сургалт 2024 оны 02-р сарын 19-нд Эрдэнэт хотод, 02-р сарын 21-нд Өвөрхангай аймгийн Арвайхээр сумд, 02-р сарын 22-нд Хархорин сумд тус тус зохион байгуулагдаж нийт салбарын 32 ажилтан хамрагдсан.



Олон нийтийн ажлын талаар: XVII жарны "Хилэнт эх" хэмээх модон луу жилийн сар шинийг тохиолдуулан тус салбарт ажиллаж байгаад гавьяаныхаа амралтыг эдэлж байгаа ахмадуудаа хүлээн авч ирж буй жилийнхээ өнгө төөрөг, өлзий дэмбэрлийг бэлгэдэн, идээ ундаагаа хүртэж, ерөөлийн бэлгэтэй үг хэлэлцэн хүндэтгэл үзүүлээ.



Орхон аймгийн Биеийн тамир спортын газар, Соёл урлагийн газраас аж ахуйн нэгж байгууллагуудын дунд "Цасны баяр-2024" арга хэмжээ зохион байгуулагдсан. Цасны баярт 23 байгууллагын 400 гаруй албан хаагч спортын 4 төрлөөр хурд, хүчээ сорин өрсөлдсөнөөс манай салбарын баг тамирчид багийн нэгдсэн дүнгээр хоёрдугаар байрт шалгарсан.

АШИГЛАЛТЫН ТҮВШИН, НАЙДВАРТАЙ АЖИЛЛАГААГ ДЭЭШЛҮҮЛЭХ ТАЛААР

Гэмтэл устгалтаар хийгдсэн ажлууд

Хялганат дэд станц Т-2 110 кВ-н ВМТ таслуурын А фазын масло заагч шил солих

Хархорин дэд станц 110 кВ Хархорин-А таслуурын В-фазын халаагуурыг хэвийн болгох




Хархорин дэд станц СВГ-н 10кВ-н оруулгын панель дотор температур болон чийгшил мэдрэгч суурилуулах

110 кВ Хархорин-А АШ-н тулгуур №753-ын II фаз, тулгуур №768-н III фазад элемент солих, 110 кВ Хархорин-Б АШ-н тулгуур №789-ын I фазад элемент солих, тулгуур №716-н II фазад утасны гэмтэл устгах




110кВ-н Мөрөн АШ-ын тулгуур №188, 201-202, 305, 466-д дамжуулагч утасны гэмтэл устгах, тулгуур №464-465-р 1-р хөндлөн траверсын гэмтэл устгах



Хархорин дэд станц Т-1 110кВ-н ОД-н гэмтлийг устгах, удирдлагаар тасалж шалгах

110 кВ Баянхонгор АШ тулгуур №74 I-р фаз тулгуур №87 II-р фаз, тулгуур №90 III-фазуудад утасны гэмтэл устгах



110 кВ-н Хархорин-Б АШ-н тулгуур №763 дээр шлеф холбох



110 кВ Баянхонгор АШ тулгуур №643 II фаз, тулгуур №656 II фаз утасны гэмтэл устгах



110 кВ-н Тэлмэн АШ-н тулгуур №388-н III фазын /5-8судал/, тулгуур №554-н III, тулгуур №567-н II, III фазын дамжуулагч утасны гэмтэл устгах



Хархорин дэд станц СВГТ-1 ТР-раас 10кВ-н ячейк руу орж байгаа кабелийн А фазын трасс өөрчлөх, муфть хийх;

Өвдөгхудаг АШ-н ВТ-н приводны халаагуур солих;


Дашинчилэн АШ-н приводны халаагуур солих зэрэг ажлууд хийгдсэн байна.

Салбарын хэмжээнд шугам, тоноглолын найдвартай ажиллагааг хангах зорилгоор дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

- 110 кВ Гок-Д АШ-н багтаамжийн хүчдэлийн трансформаторын газардлага гагнах;
- Эрдэнэт дэд станцын 0.4 кВ-н хэлхээнд гармоникийн хэмжилт хийх
- 35 кВ-н Карьер-А АШ-н У-3 панель дээр төлөвийн гэрэл солих;
- Хялганат дэд станцын удирдлагын ерөөний шитийн холболт халаагуурын хэлхээнд үйлчилгээ хийх
- Эрдэнэт дэд станцад ДҮТ-ийн СКАДА-ийн тогтмол гүйдлийн панель суурилуулах;

- Хархорин дэд станцын 10 кВ-н Р-1-н таслуурын хяналтын хэлхээг шалгах;
- Мөрөн дэд станцын 6.3 МВА-н Т-1, Т-2 трансформаторын РПН-н байрлалыг 12-14-рүү, Т-3 трансформаторын РПН-н байрлалыг 13-15-рүү шилжүүлэв.
- 110 кВ Булган-А АШ-н /П-14 дээр/ дохиоллын гэрэл солих
- 10 кВ-н ЗАШ АШ-ын РХ-ын тавил өөрчлөх;
- Хишиг-Өндөр дэд станц Т-1 35кВ оролтын тоолуурын батареи солих;
- Эрдэнэт дэд станц 6 кВ-н ДХТ-1-н тоолуурын батареи солих;
- Баянхонгор дэд станц 16 МВА Т-1 трансформаторын РПН байрлалыг 14-15-16 руу шилжүүлсэн зэрэг ажлууд амжилттай хийгдсэн.

Мэдээллийг бэлтгэсэн: ХБС-ын ЗААА-ны сургалт, бүтээмжийн инженер Б.Ундрах



ЗҮҮН-ӨМНӨД БҮСИЙН САЛБАР

ХАБЗА ЧИГЛЭЛЭЭР ХИЙГДСЭН АЖИЛ

2024 оны эхнээс урьдчилсан зааварчилгаанд шинээр ажилд орсон 5 ажилтан, сарын давтан зааварчилгаанд 364 ажилтан, ээлжит бус зааварчилгаанд 255 ажилтан, тухайлсан зааварчилгаанд 226 ажилтан, өдөр тутмын давтан зааварчилгаанд 3185 ажилтан давхардсан тоогоор тус тус хамрагдаж аюулгүй байдлыг ханган ажиллаж байна.

2024 онд мэргэжлийн зэрэг нэмэх дөрвөн ажилтны холбогдох материалыг бүрдүүлж, зэрэг нэмэх шалгалт авч компанийн мэргэжлийн зэрэг олгох комисст материалыг хүргүүлсэн.

2024 оны 1-р улирлын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг хангах болон ашиглалт засварын 3-р шатны үзлэг шалгалтыг батлагдсан удирдамжийн дагуу салбарын Ерөнхий инженер Б.Түвшинбаяраар ахлуулсан комисс 2024 оны мэдлэгийн ээлжит шалгалт авах ажлыг хамтад нь зохион байгуулж 2024 оны 01-р сарын 17-ноос 01-р сарын 30-ны өдрүүдэд Өндөрхаан, Бор-Өндөр, Баянмөнх, Чойр, Айраг, Сайншанд, Ширээт, Замын-Үүд, Борхойн, Багануур, Хот, Төв дэд станцууд, Реле хамгаалалт автоматик хэмжилт туршилтын алба, Засварын алба, Ашиглалт шуурхай үйлчилгээний алба, Захиргаа аж ахуйн алба, Тээвэр механизмын хэсэгт хийж гүйцэтгэсэн байна.

**2023 оны 4-р улирлын үзлэг шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгасан байдал:**

ХАБЗА-н үзлэг, шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгасан ажлын гүйцэтгэлийг шалгахад салбарын хэмжээнд 94,5 %-ийн гүйцэтгэлтэй, Ашиглалт засварын үзлэгийн хувьд 61.0 %-ийн гүйцэтгэлтэй гарсан байна.

2024 оны I дүгээр улирлын ХАБЗА-н

үзлэг, шалгалтаар аюулгүй ажиллагааны болон галын аюулгүй байдлыг хангах 12 үзүүлэлтээр алба, хэсэг, дэд станцуудад хяналт шалгалт хийгдэж, салбарын хэмжээнд 156 зөрчил илэрсэн бөгөөд өмнөх үзлэгээр илэрсэн зөрчлөөс 16.2%-аар буурсан үзүүлэлттэй.

Ашиглалт-засварын 7 үзүүлэлтээр засварын ажлын гүйцэтгэл, ашиглалтын

паспортын баяжилт, хөтлөлт, схем зааврын бүрдэлт, мөрдөгдөж байгаа байдал, тоноглолын үзлэг графикийн дагуу хийгдэж байгаа эсэх, өмнөх үзлэгээр илэрсэн зөрчлийг устгасан байдал зэрэгт үзлэг шалгалт хийхэд 132 зөрчил илэрсэн байна.

2024 оны мэдлэгийн ээлжит шалгалт, давтан шалгалт авах ажлыг 2024 оны 01 дүгээр сарын 10-наас 01 дүгээр сарын 30-ны хооронд ААД, ТАД, НСД, аваар устгах эмхэтгэл, болон бусад хууль, дүрэм журам, АШ-ын трассын схем, ША-ны схем зурах, сэлгэн залгалт, наряд бичих бичгийн хэлбэрээр зохион байгуулж салбарын харьяа алба, хэсэг, дэд станцуудын нийт 167 ажилтан хамрагдаж, 100%-ийн амжилттай шалгагдсан ба 2024 оны ажлын аюулгүй байдлыг хариуцагч нарын тушаалыг батлуулж гаргуулсан.

2024 оны 01-р сарын 20-ны өдөр 220/110/35/6 кВ-н Чойр дэд станцад 110 кВ-н Бор-Өндөр агаарын шугам хамгаалалтаар тасарсан шалтгааныг судалсан зөрчлийн акт №1 /сэлгэн залгалтын зөрчил-г судлан бүртгэж, ХМХ-т явуулсан.



АШИГЛАЛТЫН ТҮВШИН, НАЙДВАРТАЙ АЖИЛЛАГААГ ДЭЭШЛҮҮЛЭХ ТАЛААР

Засварын ажлын мэдээ: 2024 оны 02-р сарын 22-ны өдрийн байдлаар ашиглалтын түвшин үзлэг үйлчилгээний ажил давхардсан тоогоор 28, гэмтэл устгалын 6 ажил тус тус хийж гүйцэтгээд байна.

Хэрэглэгчдийг тасралтгүй, найдвартай цахилгаан эрчим хүчээр хангах, гэнэтийн болзошгүй аваар, саатлаас урьдчилан сэргийлэх зорилгоор шугам тоноглолд баярын өмнөх үзлэг хийх график гарган удирдлагаар батлуулж графикийн дагуу инженер техникийн ажилтнаар ахлуулсан бригад үзлэгийг 2024.01.29-02.07-ны өдрийн хооронд салбарын харьяа 220, 110 кВ ЦДАШ-уудад ээлжит үзлэгийг зохион байгууллаа.

Үзлэгийг Чойр хэсгийн засварын мастер Н.Наранбаяр, А.Энхжаргал, Сайншанд дэд станцын ашиглалт шуурхай үйлчилгээний инженер Л.Бямбадорж, Өндөрхаан дэд станцын ашиглалт шуурхай үйлчилгээний инженер Д.Баасанхүү, Чойр хэсгийн жолооч Д.Гансэлэм, Өндөрхаан дэд станцын жолооч С.Батсуурь, Сайншанд дэд станцын жолооч Б.Энхболд, салбарын жолооч Б.Алтангэрэл нар хийж гүйцэтгэв.



Нийт 19 ЦДАШ-нд үзлэг хийснээс 118 ширхэг гэмтэл илэрсэн байна. Дээрх гэмтлээс тасралтад нөлөөлөхөөр байсан дараах гэмтлүүдийг устгаж АШ-ын найдвартай ажиллагааг хангаж ажиллалаа.

Үзлэгээр илэрсэн гэмтэл устгасан байдал: 207-р ЦДАШ-нд Т№465-466 хооронд аянгын троссны 4 ширхэг судал тасарсан цэг, Т№373-374 хооронд 1 ширхэг судал тасарсан цэгүүдэд ороолт хийсэн.

Т№315 II фазын ГВН тохируулсан, А№167-н I, III фазын шлефны ПА хавчаарын боолт унасныг нөхөж хийсэн А№113, Т№121-с гаднын биет авсан. Бусад гэмтэл нь агаарын шугамын тасралтад шууд нөлөөлөхөөр гэмтэлгүй тул 2023 оны урсгал засварын ажлаар хийж гүйцэтгэхээр төлөвлөөд байна.



Сургалтын чиглэлээр: 2024 оны салбарын нэгдсэн ажлын байрны ээлжит сургалт: 2023 оны 12-р сарын 11-ний өдрөөс 2024 оны 01-р сарын 19-ний өдрийг дуустал хугацаанд салбарын хэмжээнд батлагдсан төлөвлөгөө, удирдамжийн дагуу нийт 36 цагийн ажлын байрны ээлжит сургалтыг танхимын болон цахим хэлбэрээр хослуулан зохион байгуулав. Сургалтад салбарын хэмжээнд нийт давхардсан тоогоор 800 ажилтан хамрагдсан. Сургалтын дараа хичээлтэй холбоотой сэтгэл ханамжийн судалгааг ажилтнуудаас авч нэгтгэн дүгнэлт хийж ажилласан.



2024 оны алба, хэсэг, дэд станцуудын ажлын байрны ээлжит сургалт: 2023 оны 12-р сарын 11-ний өдрөөс 2024 оны 01-р сарын 19-ний өдрийг дуустал хугацаанд алба, хэсэг, дэд станцуудад батлагдсан төлөвлөгөө, удирдамжийн дагуу нийт 221 цагийн сургалтыг зохион байгуулж давхардсан тоогоор 3208 ажилтан хамрагдсан.

Мэдээллийг бэлтгэсэн: ЗӨБС-ын
ИА-ны мэдээллийн технологи, компьютерын
инженер Б.Пүрэвсүрэн

ГОВИЙН БҮСИЙН САЛБАР

ХАБЗА ЧИГЛЭЛЭЭР ХИЙГДСЭН АЖИЛ

Салбарын хэмжээнд 2024 оны 01, 02, дугаар сард нарыаар 10, шийдвэрээр 50 ажил хийгдсэн. Наряд, шийдвэрээр ажил гүйцэтгэхэд ажлын аюулгүй байдлыг хариуцагчид болон бригадын бүрэлдэхүүнд онцгой анхааран, шат шатны зааварчилгааг чанартай өгч, хяналт тавьж ажилласан.

Салбарын хэмжээнд 21 удаагийн дасгал зохион байгуулагдаж, 123 ажилтан хамрагдсан ба сарын давтан зааварчилгааг 92 хүн, тухайлсан зааварчилгааг 624, ээлжит бус зааварчилгааг 97 хүнд өгч ажилласан байна.

Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутагт байрлах Оюутолгой дэд станцаас Оюутолгой уурхай, Оюутолгой-Гашуунсухайт боомт чиглэлийн 219, 220, 255, 256-р цахилгаан дамжуулах агаарын шугамын хамгаалалтын зурвасын дэглэм сахиулах ажлын хүрээнд засаг даргын 2024 оны 02 дугаар сарын 15-ны А/47 тоот захирамж гаргуулж газрын мэдээллийн санд оруулсан.

Салбарын ажилтнуудад аюулгүй



ажиллагааны эрх олгох 2024 оны ээлжит шалгалтыг нийт 97 ажилтнаас авсан. Шалгалтын дүнгээр ажлын аюулгүй байдлыг хариуцагч нарыг салбарын даргын 2024 оны 02 сарын 06-ны өдрийн А/06 дугаар тушаалаар баталгаажуулсан.



Ажилтнуудын шалгалт өгч буй явц

Салбарын хэмжээний аваар эсэргүүцэх дасгалыг 2024 оны 01 дүгээр сарын 28-ны өдөр Мандал дэд станцад аваарын зарлан дуудах схемийн дагуу дуудаж зохион байгуулсан. Уг дасгалыг 215:216 дугаар агаарын шугамын тулгуур №86-т үзлэгээр илэрсэн гэмтэл устгах гэсэн сэдвээр зохион байгуулсан. Өгөгдсөн сэдвийн хүрээнд аваарын үед мөрдөж ажиллах төлөвлөгөөний дагуу гүйцэтгэх ажлын төлөвлөгөө гаргаж албадын дарга нар нэг бүрчлэн танилцуулсан. Мөн аваарын бэлэн байдалд ажилласан ажилтнуудын аранзын бүрдлийг шалгахад зайлшгүй байх иж бүрдлийг хангасан байсан. Дасгалын

мөрөөр аваарын үед мөрдөж ажиллах төлөвлөгөөг шинэчлэн батлах, 2 дугаар улиралд шинэчилсэн төлөвлөгөөний дагуу дахин дасгал зохион байгуулах шийдвэр гарч салбарын нийт ажилтнуудад танилцуулсан.



Аваар эсэргүүцэх дасгалын дүгнэлт танилцуулах, аранзын бүрдлийг шалгаж буй явц

Компанийн 1-р улирлын аваар эсэргүүцэх дасгалыг Шуурхай зохицуулалтын хэлтсийн диспетчер инженер Базарвааниар ахлуулсан диспетчер инженерүүд Мандал дэд станцад ирж зохион байгуулж шуурхай ажиллагааны 20 ажилтан хамрагдсан.

Мөн энэ үеэр шуурхай ажиллагааны ажилтнуудад “Сэлгэн залгалт” сэдвээр сургалт орж бататгах шалгалтыг авсан.



Аваар эсэргүүцэх дасгалын явц

АШИГЛАЛТЫН ТҮВШИН, НАЙДВАРТАЙ АЖИЛЛАГААГ ДЭЭШЛҮҮЛЭХ ТАЛААР

Салбарын харьяа ЦДАШ-уудад баярын өмнөх ээлжит үзлэг хийв

Сар шинийн баярын өмнөх үзлэгийг 215:216-р агаарын шугамд 2024 оны 01 дүгээр сарын 16-19-ний хооронд, 221:222-р агаарын шугамд 01 дүгээр сарын 23-24-нд, 217:218-р агаарын шугамд 01 дүгээр сарын 25-26-нд, 110 кВ Даланзадгад агаарын шугамд 01 дүгээр сарын 16-17-ны өдрүүдэд, 213:214-р агаарын шугамд 02 дугаар сарын 01-02-ны өдрүүдэд тус тус хийж, үзлэгийн тайланг холбогдох ажилтнуудад танилцуулан ажилласан.



Агаарын шугамын үзлэг хийх үе

110/35/10 кВ Мандалговь дэд станцын Т-1 110 кВ-н ЭТ-г шилжүүлэх ажил хийгдэв.

ЦДҮС ТӨХК-ийн Төвийн бүсийн салбарт 2024 оны 02 дугаар сарын 08-ны өдөр

гарсан гэмтлийн мөрөөр засварын албаны дарга О.Хоринтаванаар ахлуулсан 11 хүний бүрэлдэхүүнтэй бригад, 2 машин механизмтай 110/35/10 кВ-н Мандалговь дэд станцын Т-1 110 кВ-н элегаз таслуурыг буулгаж, Төвийн бүсийн салбарт хүргүүлэх ажил гүйцэтгэсэн.



Тоноглолыг буулгаж ачиж буй явц

"Клин Энержи Ази" ХХК-тай байгуулсан гэрээний дагуу 110/35 кВ Цэций салхин цахилгаан станц болон 147:148-р АШ-н 01, 02 дугаар сарын ээлжит үзлэг шалгалтыг хийж, ходбогдох мэдээ тайланг хүргүүлэн ажилласан.



Цэций СЦС-ын тоноглол, 147:148-р АШ-ын үзлэг хийж байгаа нь

Дэд станцуудад шуурч хунгарласан цас болон кабель шугамын лоткины цас хайлж шар усны үер болохоос урьдчилан сэргийлэх зорилгоор 2024 оны 2 дугаар сарын 3,4-ний өдрүүдэд цасыг цэвэрлэх ажлыг шуурхай ажиллагааны ажилтнууд хийж гүйцэтгэсэн.

Ажлын байр болон онцгой объектуудын дээврийн цас хайлж нэвчихээс урьдчилан сэргийлж 2024 оны 02 дугаар сарын 19,20-ны өдрүүдэд дэд станцуудын шуурхай удирдлагын байр болон ХХБ-уудын дээврийн цасыг цэвэрлэх ажлыг бүрэн хийж гүйцэтгэсэн.



Тоноглолыг буулгаж ачиж буй явц

Дэд станцын удирдлагын байрны дээврийн цас цэвэрлэж буй явц

Техникийн ажилтнуудад сургалт зохион байгууллаа.

Салбарын техникийн албаны ажилтнуудад засварын ажил эхлэхтэй холбогдуулан алдаа дутагдал гаргахаас урьдчилан сэргийлэх зорилгоор 2024 оны 01 дүгээр сарын 29-ний өдөр сургалт зохион байгуулсан. Тус сургалтаар техникийн

албадуудын ажлын зохион байгуулалт болон өмнө гарч байсан зөрчлүүдийг танилцуулж гарсан алдааг дахин гаргахгүй байхад анхаарч ажиллах талаар зөвлөмж өгсөн.




Техникийн албадын ажилтнуудын сургалт

“Инженер техникийн ажилтнуудын цаг”-ийг зохион байгуулав.

Салбарын даргын 2024 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн А/01 тушаалаар “Инженер техникийн ажилтнуудын цаг” болзолт уралдааныг бүтэн жилийн хугацаанд салбарын бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй ажилтнуудын дунд зохион байгуулахаар удирдамж, хөтөлбөрийг баталсан. Хөтөлбөрт тусгасны дагуу шугамын засварын мастер Б.Лхагвасүрэн ахлагчтай 1-р баг 2024 оны 02 дугаар сарын 20-нд нэг өдрийн Инженер техникийн ажилтнуудын цагийг зохион байгуулсан. Тус баг нь “Техникийн алдагдал түүнийг тодорхойлох, цаашид авах арга хэмжээ” сэдвийн хүрээнд илтгэл тавьж сургалт явуулсан. Мөн ажилтнуудын дунд мэргэжлийн холбогдолтой асуултаар танин мэдэхүйн АХА тэмцээнийг зохион байгуулав.

Мэдээллийг бэлтгэсэн: ГБС-ын ЗААА-ны дарга Ц.Ганнэгт



ЯПОНЫ ЖАЙКА ОУХАБ-ЫН ЭХС-Д ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ ТӨСЛИЙН СУРГАЛТЫН ТАЛААР ТОВЧ

"Сэргээгдэх эрчим хүчний оролцоо ихтэй эрчим хүчний системийн тогтвортой байдлыг нэмэгдүүлэх, чадавхыг бэхжүүлэх төсөл"-ийг Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага (JICA)-тай хамтран зохион байгуулж байгаа бөгөөд тус төслийн хүрээнд ЭХС-ын инженерүүдийн чадавхыг бэхжүүлэх сургалт, судалгааны ажлыг уг төслийн хэрэгжих 3 жилийн хугацаанд зохион байгуулахаар болсон бөгөөд манай компаниас 30 ажилтныг 4 чиглэлээр /Повер фактор, РХА, Шугам, Тоноглолын засвар, оношилгоо/ сургаж байна. Энэхүү төслийн эхний сургалт 2022 оны 12 дугаар сарын 06-ны өдрөөс SWG-3 "Повер фактор" сургалтаар эхэлсэн бөгөөд өнөөдрийн байдлаар Япон дахь сургалт 3 удаа, Монгол дахь сургалт 4 чиглэлээр 8 удаа тус тус зохион байгуулагдаад байна. Мөн энэ хугацаанд олон удаагийн цахим сургалтыг зохион байгуулж, харилцан мэдээлэл солилцож ажиллалаа. Энэ сургалтын хүрээнд Жайка байгууллага нь манай компанид Повер фактор программын 2023 оны шинэ хувилбарыг буюу PF-2018 (Power factor) программыг PF-2022 болгон худалдан авч гардуулан өгсөн бөгөөд холбогдох ИТА-нуудыг тус шинэ хувилбар дээр сургах ажлыг зохион байгуулж байна. Тус төслийн хүрээнд манай ажилтнууд өөр өөрсдийн ажил үүргийн чиг хүрээнд шаардлагатай шинэ техник технологийг судалж, арга технологийг нэвтрүүлэхэд дөхөм болохуйц мэдлэг мэдээллийг тодорхой хэмжээгээр олж авах байх гэж найдаж байгаа. Төслийн хугацаанд оролцогч талууд хамтран дараах үр дүнд хүрэх зорилго тавиад ажиллаж байна. Үүнд:

SWG-1 /RTDS/

- Энэхүү программыг манай холбогдох ажилтнууд ашиглаж сурах. Манай компанид 1 сургагч багшийг бэлтгэн өгөх

SWG-3 /PF/

- PF-2018 (Power factor) программыг PF-2022 болгон шинэчлэсэн. Программ худалдан авсантай холбогдуулан компанийн хэмжээнд ажиллаж буй реле хамгаалалт автоматикийн тавил тооцоо, горим тооцооны инженерүүдийг программ ашиглалтын сургалтад хамруулж байна. Ингэснээр салбарын горим тооцооны инженерүүд сүлжээний загварчлалын сайжруулалтыг хийх, холбогдох горимын тооцоонуудыг тогтворжсон горимын тооцоо хэлбэрээр гүйцэтгэх чадвартай болох ба ахисан түвшний сургалтад хамрагдсан инженерүүдийн хувьд тогтворжилт, гармоникын функцүүдийг судлах боломж бүрдэж байгаа юм.

- Нэг сургагч багшийг бэлтгэх

SWG-4 /РХА/

- РХА-н заавартай тавилын картыг /МАР буюу газрын зураг хэлбэрт оруулж/ Япон Улсад одоо хэрэглэж байгаа хэв загварт оруулан боловсруулж ажлын байранд байршуулах юм. Карт бүрийн дор энэхүү тавил нь ийм ийм асуудлуудыг хангадаг гэсэн тавилыг тавьж буй үндэслэлийг тайлбарласан байдлаар хийгдэнэ. Эхний ээлжинд жишиг байдлаар УБС-ын бага тойргийн схемийн загвараар боловсруулж байгаа. Явц: 90%

SWG-5,6 /Шугам, дэд станц/

- Төслийн хүрээнд ЦДАШ-ын дамжуулагч утасны хуучралтыг оношлох, төмөр тулгуурын цайрын бүрээсийн элэгдлийн түвшинг тодорхойлох, үзлэг шалгалт хийх гарын авлга боловсруулах ажил хийгдэж байна. Энэхүү гарын авлагыг боловсруулж ажилд нэвтрүүлснээр дамжуулагч утас ба төмөр тулгуурын насжилтыг тодорхойлох, шинэчлэх, засварлах хугацааг олон жилийн өмнөөс тодорхойлж төлөвлөх боломжтой болно.
- Дэд станцын тоноглолын үзлэг, үйлчилгээний гарын авлагын загвар боловсруулж байна. Эхний ээлжинд трансформатор болон бусад үндсэн тоноглолын үзлэг, үйлчилгээ, оношилгооны хугацаа зэргийг боловсруулж байна. 2024 оны 3-р сард сүүлийн байдлаар хянаж зөвшилцөхөөр болсон.

ТӨСЛИЙН ЯПОН УЛС ДАХЬ СУРГАЛТЫН ТАЛААР ТОВЧ:

1. Жайка: SWG-4,5,6 багуудын Япон Улс дахь I Ээлжийн сургалт.

Тус сургалт 2023 оны 06 дугаар сарын 11-ний өдрөөс 06 дугаар сарын 24-ний өдрийг дуустал хугацаанд зохион байгуулагдсан бөгөөд манай компаниас нийт 7 ажилтан хамрагдсан. Тус баг нь Япон Улсын Токио хотод буй JICA-н сургалтын төвд байрлаж сургалтад хамрагдсан бөгөөд хөтөлбөрийн дагуу TEPCO-н газар доорх 275/66/22 кВ-ын газар доорх Таканава дэд станц, TEPCO-н Харилцаа холбоо, мэдээллийн сүлжээний үйл ажиллагаа, Диспетчерийн төв удирдлагын үйл ажиллагаа, 500/154/66 кВ-ын Хамагаши дэд станц, Устөрөгчийн үйлдвэрлэл судалгааны төв гэх мэт газруудын үйл ажиллагаатай танилцаж туршлага судаллаа. Мөн эрчим хүчний хуримтлуур (батареи болон усан цэнэгт станц)-ын талаар холбогдох мэргэжилтнүүдийн тавьсан лекцэд сууж,



мөн РХ болон ЦДАШ-н чиглэлийн баг тус бүрийн боловсруулж буй баримт бичгийн хэлэлцүүлэгт оролцсон.



2. Жайка: SWG-1,3 багуудын Япон Улс дахь сургалт.

Тус сургалт 2023 оны 11 дүгээр сарын 12-ны өдрөөс 11 дүгээр сарын 24-ний өдрийг дуустал хугацаанд зохион байгуулагдсан бөгөөд манай компаниас нийт 13 ажилтан хамрагдсан. Хөтөлбөрийн дагуу RTDS, Power Factor программ ашиглалтын сургалтууд болон Япон орны ЭХ-ний үйл ажиллагаа, Япон Улсад HVDC буюу өндөр даралтын тогтмол гүйдлээр ЦЭХ-г дамжуулж буй жишээ, Дараагийн үеийн ХМХ-үүд SCADA, Ус хуримтлуурын цахилгаан станц, Японы СЭХ-ний үйлдвэрлэлийн таамаглал, ЭХ-ний системийн төлөвлөлт хийх хувилбарын судалгаа гэх сэдвүүдээр лекц сонсож, TEPCO PG диспетчерийн төв, Газрын доорх Шинэ Тоёосу дэд станц, Имайчи усан цэнэгт цахилгаан станц, Хог хаягдлыг шатааж ЦЭХ

үйлдвэрлэдэг Каназава үйлдвэр, Чигасаки судалгааны төв /RTDS/, TEPCO PG Диспетчерийн Канагавагийн төв, Тошиба ХК гэх байгууллагуудын үйл ажиллагаатай танилцлаа.



3. Жайка: SWG-3,4,5,6 багуудын Япон Улс дахь II Ээлжийн сургалт.

Тус сургалт 2024 оны 02 дугаар сарын 25-ны өдрөөс 03 дугаар сарын 08-ны өдрийг дуустал хугацаанд зохион байгуулагдахаар зохион байгуулалтын бэлтгэл арга хэмжээнүүд бүрэн авагдаад манай компаниас нийт 12 ажилтан хамрагдаад байна. Энэхүү сургалтын хөтөлбөрийн гол агуулгад Дамжуулах сүлжээний шугам, дэд станцын тоноглолын засвар, ашиглалт, оношилгооны чиглэлээр түлхүү сэдвүүд орсон байгаа болно.



ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛ БОЛЛОО

Төлөөлөн удирдах зөвлөлийн ээлжит хурал 02 дугаар сарын 27-ны өдөр болж өнгөрлөө. Тус хурлаар компанийн 2024 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулах тухай, компанийн 2024 оны бизнес төлөвлөгөө, компанийн зохион байгуулалтын бүтцэд нэмэлт өөрчлөлт оруулах зэрэг асуудлыг хэлэлцэн шийдвэрлэлээ. Тодруулбал, компанийн 2024 оны техник, эдийн засгийн үндсэн үзүүлэлт зорилтот түвшинд баталсан 16,032.0 сая төгрөгийн их засвар, техник зохион байгуулалтын арга хэмжээ, хөрөнгө оруулалтын ажлаас эх үүсвэр дутагдалтай байгаа 3,783.9 сая төгрөгийн ажлын санхүүжилт шийдэгдтэл компанийн 2024 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулах асуудлыг хэлэлцэж, санал нэгтэй дэмжлээ. Мөн компанийн 2024 оны бизнес төлөвлөгөөг баталсан бөгөөд дотоод аудиторын асуудлыг хэлэлцэн шийдвэрлэв.



О.ДӨЛГӨӨН ГОВИЙН БҮСИЙН САЛБАРЫН ЕРӨНХИЙ ИНЖЕНЕРЭЭР ТОМИЛОГДЛОО

Тус салбарын хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн инженер Отгонбаярын Дөлгөөн 2024 оны 02 дугаар сарын 01-ний өдөр ерөнхий инженерээр томилогдов. ЦДҮС ТӨХК-ийн отгон салбарын ерөнхий инженерээр томилогдсон О.Дөлгөөнд компанийн хамт олны нэрийн өмнөөс баяр хүргэж, ажил хөдөлмөрийн өндөр амжилт хүсье!

ЗҮҮН-ӨМНӨД БҮСИЙН САЛБАРЫН УДИРДЛАГУУД ШИНЭЭР ТОМИЛОГДОВ

Энэ сарын 28-ны өдөр Зүүн-Өмнөд бүсийн салбарын удирдлагууд шинээр томилогдлоо. Салбарын даргаар Реле хамгаалалт автоматик, хэмжилт туршилтын хэлтсийн реле хамгаалалт, автоматикийн инженер Г.Хүрэлхүү, Ерөнхий инженерээр тус салбарын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн инженер Д.Анхбаяр нар тус тус томилогдож, ажлаа хүлээн авлаа. Зүүн-Өмнөд бүсийн салбарын шинэ удирдлагууддаа, компанийн хамт олны нэрийн өмнөөс баяр хүргэж, ажлын амжилт хүсье!



Шалархал

Улаанбаатар салбарын засварын албанаас компанийн спорт зааланд чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх залуусыг дэмжиж чанарын өндөр шаардлага бүхий сагс, волейболын бөмбөг тус бүр нэг ширхгийг бэлэглэсэн байна.

УБС-ын Засварын албаны залуустаа баярлалаа.



“НЭГЭН ЖАРНЫ ТҮҮХ” БУЛАН

ТАЙЛБАР: Монгол Улсад цахилгаан дамжуулах сүлжээ үүсэж хөгжсөний нэгэн жарны түүхэн ой 4 жилийн дараа тохиох болно. Түүхийн үйл явцтай холбогдуулан Дамжуулах сүлжээ сонинд “НЭГЭН ЖАРНЫ ТҮҮХ” буланг Ахмадын хорооноос шинээр нээж техникийн дэвшил, түүнийг эзэмшигч хөдөлмөрийн хүмүүсийн тухай цувралаар нийтэлж байна. Бид өмнөх дугаартаа Говийн бүсийн салбарын түүхэн товчооныг хүргэсэн бол энэ дугаартаа үргэлжлэлийг нийтэлж байна.

ГОВИЙН БҮСИЙН САЛБАРЫН ОН ДАРААЛЛЫН ТОВЧООН (ЦУВРАЛ-6)

2015 он: МУ-ын Ерөнхийлөгчийн санаачилгаар эхлүүлсэн цөлжилтийг сааруулах, ойжуулах ногоон хэрэм төслийг дэмжин, Тавантолгой дэд станцыг элсний нүүдлээс хамгаалах тоноглолуудад үзүүлэх говийн салхи, шуурганы хүчийг сааруулах, тоосжилтыг багасгах, ажилтнуудын экологийн боловсролыг дээшлүүлэх зорилгоор заг, хайлаас, буйлс, сухай зэрэг 5 төрлийн 460 ширхэг суулгацыг салбарын хамт олны хүчээр тарьж ургуулсан.

Салбарын диспетчерын удирдлагын алсын хяналтын СКАДА систем нэвтрүүлэх ажлын эхний шатны “Мандалговь дэд станцад HMI” ажилд шаардлагатай материалын задаргаа, ажлын эзлэхүүнийг гаргаж компанийн ҮТЗ-ийн 3-р улирлын хурлаар хэлэлцүүлж шийдвэрлүүлсэн.

Салбарын Даланзадгад дэд станцын ээлжийн монтёр Г.Энхболд хийж хэрэгжүүлсэн ажлаараа 2015 оны компанийн “Хөдөлмөрийн аварга ашиглалтын монтёр”-оор шалгарсан. Салбарын Тэргүүний ажилтнаар Тавантолгой дэд станцын ахлах инженер Б.Мянганбуу, суудлын автомашины жолооч Д.Түвшинбаатар, засварын монтёр Ө.Отгонзаяа нар тус тус шалгарсан.

2016 он: Компанийн хэмжээний 2016 оны спортын аварга шалгаруулах 7 төрөлт тэмцээнд тус салбарын баг тамирчид 6 төрөлд 7 байр эзэлж түүхэн амжилт гаргасан. Гар бөмбөгийн төрлөөр засварын монтёр М.Даваадорж ахлагчтай эрэгтэй баг тамирчид Алтан медаль, сагсан бөмбөгийн төрлөөр Ш.Пүрэвсүрэн ахлагчтай эмэгтэй баг тамирчид Хүрэл медаль, ганцаарчилсан төрлөөр засварын монтёр Д.Наваанжаргал зуун буудалт даамны эрэгтэй төрөлд Алтан медаль, шатрын эрэгтэй төрөлд Хүрэл медаль, биллиардын эрэгтэй төрөлд Захиргаа, аж ахуйн албаны дарга Ш.Энхбат Хүрэл медаль, дартсын төрлөөр хүний нөөцийн мэргэжилтэн Ц.Ганнягт, жолооч Б.Түвдэндорж нар Хүрэл медаль тус тус хүртсэн.

Тавантолгой дэд станц нь ажлын байрны соёл 5С-ийн хүрээнд хийсэн ажлаараа 2016 оны компанийн “Шилдэг дэд станц”-аар шалгарсан амжилт гаргасан.

Захиргаа, аж ахуйн албанаас салбарын туслах аж ахуйг хөгжүүлэх чиглэлээр “Хамтын ажиллагаа” өдөрлөгийг нийт ажилтнуудын дунд 2016 оны 04 дүгээр сарын 06-ны өдрөөс 09 дүгээр сарын 28-ны хооронд зохион байгуулсан. Уг өдөрлөгийн хүрээнд нийт 1846м² ил талбайд 320кг төмс, 0.5 кг лууван, 7,5 кг тагар сонгинын үр, 272 м² хүлэмжинд 80 ширхэг өргөст хэмхний үрсэлгээ, 254 ширхэг улаан лооллын үрсэлгээ, 46 ширхэг чинжүүний үрсэлгээ суулгаж, ажилтнууд батлагдсан хуваарийн дагуу ажлын бус цагаар хүнсний ногоог усалж, зэрлэг ургамлыг зулгааж цэвэрлэх ажлыг гүйцэтгэсэн. Нарийн ногоог ургалтын явцад нь хурааж, ажилтнуудад зах зээлийн үнээс арай хямдаар зарж өрхийн хэрэгцээг хангасан. Ургац хураалтаар нийт төмс-1,2тн, өргөст хэмх-150кг, улаан лооль-107кг, чинжүү-7.8кг, тагар сонгино-62кг хураан авсан.

Тавантолгой дэд станцын ажилтнуудын нийгмийн асуудлыг шийдэхийн тулд Өмнөговь аймгийн Цогтцэций сумын төвд 0.7 га газрын зөвшөөрөл авч сумын Засаг даргын захирамж гаргуулан тухайн газар дээр блокоор хашаа барих ажлыг өөрсдийн хүчээр хийж гүйцэтгэсэн.

2017 он: Дорноговь аймгийн Мандах, Хатанбулаг сумд, стратегийн ач холбогдол бүхий Цагаансуварга орд газрыг найдвартай, тасралтгүй цахилгаан эрчим хүчээр хангах зорилгоор 220/110/35 кВ-ын Оюутолгой дэд станцад АТДЦН-125000 Маркийн иж бүрдэл автотрансформатор, 220 кВ-ын Цагаансуварга А,Б гаргалгаа болон 35 кВ-ын Ханбогд гаргалгааны анхдагч болон хоёрдогч хэлхээний тоноглол суурилуулах өргөтгөлийн ажлыг аюул осолгүйгээр амжилттай дуусгасан. 2017 оны 06 дугаар сарын 19-нд 220 кВ Цагаансуварга агаарын шугамаар 220/22 кВ-ын Цагаансуварга дэд станцад хүчдэл өгч Мандах, Хатанбулаг сумдын хэрэглэгчид төвийн эрчим хүчний системтэй амжилттай холбогдсон.

Компанийн 2017 оны Хөдөлмөрийн аварга засварын монтёроор Э.Дөлбадрах шалгарч, салбарын Тэргүүний ажилтнаар Оюутолгой дэд станцын ээлжийн монтёр Н.Батням, хэмжүүр тоолуурын инженер Х.Дашням, хүний нөөцийн мэргэжилтэн Ц.Ганнягт нар шалгарсан.

2018 он: 110 кВ Тавантолгой-Даланзадгад ЦДАШ-д гэмтэл устгах их засварын ажлыг 2018 оны 05 дугаар сарын 19-23-ны өдрүүдэд Улаанбаатар салбар, Төвийн бүсийн салбар, Говийн бүсийн салбарын засварын албаны нийт 5 бригад 40 хүний бүрэлдэхүүнтэй автовышка-4, АГП-1 тусгай зориулалтын автомашинтай ажиллаж амжилттай гүйцэтгэсэн. Уг засварын ажлаар нийт 24000м дамжуулагч утас, 1200м аянгын троссыг сольж, 102 тулгуурт 612 ширхэг ГВН нэмж тавьсан.

Компанийн хэмжээнд 5С-ийг амжилттай хэрэгжүүлсэн 2018

оны “Шилдэг дэд станц”-аар 110/35/10кВ Даланзадгад дэд станц шалгарсан.

“Клин Энержи Ази” ХХК-ийн Цэций салхин парк нь ашиглалтад орж хамтран ажиллах гэрээний дагуу тус салхин цахилгаан станц болон шугамын ашиглалт, засвар үйлчилгээг 2018 оны 06 дугаар сараас Говийн бүсийн салбар хариуцан ажиллаж эхэлсэн.

ДЗДЦС нэгдсэн сүлжээтэй 2018 оны 09 дүгээр сард зэрэгцээ ажиллагаанд орсноор 110 кВ-н Тавантолгой-Даланзадгад ЦДАШ нь 2 талын тэжээлтэй буюу транзит шугам болсон. Даланзадгад дэд станцад ДҮТ-ээс батлагдсан тавилын дагуу ЧВА, АЧР болон 110 кВ Даланзадгад АШ, дэд станцын тавил тавил тохиргоо хийж, ажиллагааг шалган ДЗДЦС төвийн бүсийн нэгдсэн системтэй амжилттай зэрэгцээ залгагдсан.

110/35/10кВ Мандалговь дэд станцын 110кВ-н Чойр-Мандалговь, Мандалговь-Тавантолгой АШ-н үндсэн РХ-н ажиллагааг тавилын дагуу шалгаж, наклад ажилд оруулж, АПВ ажиллах боломжтой болгосноор найдвартай ажиллагааг хангав.

Тус салбарын 2018 оны Тэргүүний ажилтнаар засварын монтёр М.Даваадорж шалгарсан.

2019 он: 220/110/35кВ-ын Оюутолгой дэд станцаас Оюутолгой уурхайг хэсэгчлэн хангах зорилгоор 2019 онд 220/35 кВ-ын 10.2 км ЦДАШ-ын барилга угсралтын ажил хийгдэж Оюутолгой уурхайн гаргалгааны тоноглолуудыг угсарч өргөтгөл хийгдсэн.

220/110/35 кВ-н Мандал дэд станц БНХАУ-ын хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрээр 2018-2019 онд 330 кВ-ын Сонгино-Мандал ЦДАШ, дэд станц барих төслийн хүрээнд 220/110/35 кВ-н Мандал дэд станц 2019 оны 10 дугаар сарын 07-ны өдөр 225-р АШ-аар туршилтын хүчдлийг залгасан ба 2019 оны 10 дугаар сарын 18-ны өдөр албан ёсоор ЦДҮС ТӨХК-ийн Говийн бүсийн салбарт харьяалагдах болсон. 220/110/35 кВ-н Мандал дэд станц нь БНХАУ-д үйлдвэрлэгдсэн 63 МВА-ын 2 автотрансформатортай ба нийт суурилагдсан хүчин чадал 126 МВА. 213, 214-р АШ-р 220/110/35 кВ-н Сонгино дэд станцтай, 215, 216-р АШ-аар 220/110/35/10 кВ-н Тавантолгой дэд станцтай холбогдсон. 35 кВ талдаа 5 гаргалгаатай Дундговь аймгийн төв болон 11 сумын хэрэглэгчдийг төвийн бүсийн нэгдсэн сүлжээнээс ЦЭХ-ээр хангаж байна.

Компанийн хөрөнгө оруулалтаар салбарын оффисын зориулалттай зоорийн давхар бүхий 3 давхар барилгын ажлыг Сэнэо констракшн ХХК гүйцэтгэн ашиглалтад оруулж 2019 оны 11 дүгээр сарын 07-ны өдөр нээлтээ хийсэн.

110/35/10 кВ-ын Даланзадгад дэд станцын 35 кВ-ын ИХБ нь Даланзадгад ДЦС-ын ус хөргөх байгууламжийн салхин доор нь байрладаг учраас 35 кВ-ын ИХБ-н тоноглолуудын хөндийрүүлгийг муутгаж, хөндийрүүлэгч нэвт цохигдох, хүйтний улиралд тасралт гарах нөхцөл үүсэж байсан. Иймд 35 кВ-ын Далан А, Б АШ-ын порталыг ашиглан салхи нэвтэрдэг зориулалтын торон хашаагаар 35 кВ-ын ИХБ-ын тоноглолуудад уурын хаалт барьж угсрах ажлыг хийж гүйцэтгэсэн.

ДЗДЦС нэгдсэн сүлжээтэй 2018 оны 09 дүгээр сард зэрэгцээ ажиллагаанд орсноор 110 кВ-н Тавантолгой-Даланзадгад ЦДАШ нь 2 талын тэжээлтэй буюу транзит шугам болсон. Иймд тус шугамын РХБ-ыг өндөр давтамжийн хоригтой үндсэн хамгаалалттай болгон шинэчлэн зохион байгуулсан.

Тус салбарын 2019 оны Тэргүүний ажилтнаар тооцооны нягтлан бодогч Т.Оюунбилэг шалгарсан.

2020 он: 2020 оны 08 дугаар сарын 15-нд 110/35/10 кВ-ын Тавантолгой дэд станц нь 215, 216-р АШ-аар 220 кВ-н хүчдэлийн түвшинд шилжсэн. УХЦС, Цэций Салхин цахилгаан станц зэрэг эх үүсвэрүүдтэй синхрон холбогдсон, Монгол орны стратегийн чухал орд болох Тавантолгой орд газрыг түшиглэн баригдсан дэд станц юм. 16 МВА-н суурилагдсан хүчин чадалтай SFSZ-16000/115 маркийн 2 трансформатор, 125 МВА суурилагдсан чадалтай OSFPSZ-125000 /220*2 автотрансформатор/ 220 кВ-н 215, 216-р АШ 249,8 км, 217, 218-р АШ 136,3 км, 110 кВ-н Ухаахудаг А,Б АШ-15 км, 110 кВ-н Даланзадгад АШ-86.9 км, 147, 148-р АШ 33.8 км, 110 кВ-н Цанхи-А,Б АШ-13.8 км, 35 кВ-н Манлай АШ 110 км, Ёл АШ-26 км, 35 кВ-н Төмөрзам-1.2 АШ-20.9 км, 35 кВ-н Зэрэглээ-А,Б АШ-17 км, 10 кВ-н Тосгон АШ-7.5 км, Эрдэнэс АШ-5.4 км, Вагнер АШ-6.2 км, Хишиг-Арвин АШ-15 км, Моннис АШ-5.5 км гарсан шугамуудтай ба 35/10 кВ-н талаас 586 айл өрх, 124 албан газар, Эрдэнэс-Тавантолгой ХХК, Тавантолгой ХК, Хишиг-Арвин ХХК зэрэг уурхайн кемпүүд, Ёл повер ХХК, Вагнер-Ази ХХК-н засварын газруудыг тэжээдэг.

Тус салбарын 220/110/35 кВ Оюутолгой дэд станцын ээлжийн монтёр Гантөмөрийн Нарангэрэл нь компанийн 2020 оны Хөдөлмөрийн аварга ашиглалт шуурхай үйлчилгээний монтёроор

шалгарсан бол салбарын “Тэргүүний ажилтан”-аар засварын албаны шугамын засварын монтёр А.Дорждэрэм шалгарсан.

2021 он: 220/22/35 кВ-н Цагаансуварга дэд станц нь 2014 онд баригдаж 2017 оны 6 дугаар сарын 20-ны өдөр 35 кВ-н хүчдэлээр ДХТ болон Дорноговь аймгийн Мандах, Хатанбулаг сумдын хэрэглэгчдийг тэжээж эхэлсэн. 2021 оны 6 дугаар сарын 24-ний өдөр 220 кВ-н хүчдэлд залгагдсан.

110/35/10 кВ-н Даланзадгад дэд станцын ИХБ-нд хайрга дэвсэх ажлыг 2021 оны 10 дугаар сарын 20-ны өдрөөс 11 дүгээр сарын 01-ний өдрүүдэд бүрэн хийж гүйцэтгэсэн. Говийн шаварлаг хөрстэй тоосжилт ихтэй газарт хайрга дэвсэх арга хэмжээг авснаар тоноглолын бохирдол болон зуны улиралд борооны ус тогтох нөхцөлийг бууруулсан.

Салбарын бүс нутгийн хэмжээнд 2021 оны хавар өмнөх жилүүдээс шороон шуурга ихээр шуурсантай холбогдуулан дэд станцын ИХБ-н тоноглол, тоноглолын удирдлагын шкафууд, дэд станцын хашаа, кабель шугамын лоткинд элс дүүрсэн. Салбарын харьяа дэд станцуудын элс шорооны цэвэрлэгээг хийж, удирдлагын шүүгээ, клемний шкафуудын битүүмжлэлийг сайжруулсан. 220/110/35/10 кВ Мандал дэд станцын хашаа дагасан шуурсан элсийг зайлуулан дахин элс шуурах, элсний нүүдлийг тогтоох бууруулах зорилгоор далан хийсэн.

Монгол Улсын стратегийн чухал орд газар болох Тавантолгойн нүүрсний уурхайг тэжээх 110/35/6 кВ Цанхи дэд станцад 2021 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр Эрчим хүчний хөгжлийн төв, Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн, ЦДҮС ТӨХК, Грийн энержи ХХК-ийн хамтарсан техникийн комисс ажилласан. Тус техникийн комиссын шийдвэрээр 220/110/35/10 кВ Тавантолгой дэд станцаас 110 кВ Цанхи-А, Б АШ-аар 110/35/6 кВ Цанхи дэд станцыг туршилтын хүчдэлд амжилттай залгасан.

110/35/6 кВ Цанхи дэд станцыг хүчдэлд залгахтай холбогдуулан 220/110/35/10 кВ Тавантолгой дэд станцад 110 кВ Цанхи-А, Б АШ-н реле хамгаалалтын тавил тохиргоог хийж, хамгаалалтын ажиллагааг шалгах ажлыг тус салбарын РХАХТА-ны ажилтнууд хийж гүйцэтгэсэн.

220/110/35/10 кВ Тавантолгой дэд станцад төмөр замын 35 кВ Зэрэглээ-А,Б гаргалгааны тоноглол суурилуулах, холболт хийх ажлыг “Эрчим инженеринг” ХХК хийж гүйцэтгэсэн.

Компанийн 2021 оны Хөдөлмөрийн аварга удирдах ажилтнаар Реле хамгаалалт, автоматик, хэмжилт туршилтын албаны дарга Т.Цэнгэл, салбарын Тэргүүний ажилтнаар салбарын диспетчер инженер Б.Үүрийнтуяа шалгарсан.

2022 он: Салбарын 10 жилийн ойг угтаж хамт олны нөхөрсөг уур амьсгалыг бүрдүүлэх, багаар ажиллахад сургах, бүтээлч ажлын идэвхийг дээшлүүлэх зорилгоор ажилтнуудын төрсөн ордоор хуваарилсан багуудын дунд болзолт уралдааныг 6 сарын хугацаанд зохион байгуулсан. Уг уралдааныг хэрэгжүүлэх зарчим нь нийт ажилтнуудыг төрсөн сар өдрөөр нь 12 ордонд хуваарилж, багийн гишүүдийн тоог тэнцвэртэй байдлаар 2 ордыг нэгтгэн 6 багт хуваасан. Эдгээр 6 баг оногдсон сардаа батлагдсан төлөвлөгөөний дагуу бүтээлч ажлуудыг санаачлан зохион байгуулж хийсэн ажлын тайлан, зургийн цомгийн хамт салбарын удирдлагуудад хүлээлгэж өгч ажилласан. Уралдаанд оролцож байгаа багууд 6 сарын хугацаанд нийт 107 төрлийн ажлыг төлөвлөн гүйцэтгэсэн байна. Болзолт уралдааны үр дүнгээр салбарын өнгө үзэмж сайжирч, тохижилтын ажлууд хийгдэж, ажилтнуудын бүтээлч хандлага, жигд оролцоог хангаж багаар ажиллах урам өгсөн онцлог ажил болсон.

Компанийн 2022 оны Хөдөлмөрийн аварга засварын монтёроор дэд станцын засварын монтёр Ө.Отгонзаяа, салбарын Тэргүүний ажилтнаар салбарын Даланзадгад дэд станцын ээлжийн техникч Б.Бямбасүрэн шалгарсан.

Цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцуудын ашиглалтын түвшинг дээшлүүлэх, засварын ажлын чанар, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, аливаа зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг сайжруулан ажлын хариуцлага сахилга бат, урам зоригийг дээшлүүлэн ажилтнуудад эерэг хандлага төлөвшүүлэх төлөвшүүлэх зорилготой Засвар, ашиглалтын чанарыг дээшлүүлэх уралдаанд тус салбар Тэргүүн байр эзэлсэн.

2023 он: Монгол орны гал голомтыг мөнхөд бадрааж, илч гэрлийг тасралтгүй найдвартай дамжуулах үйлсийн гэрч болж нэгэн аравны арвин түүхийг бүтээсэн ЦДҮС ТӨХК-ийн Говийн бүсийн салбарын 10 жилийн түүхэн ой тохиосон.

Үргэлжлэлийг дараагийн дугаарт

Эрхлэн гаргасан: Захиргаа удирдлагын хэлтсийн хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах мэргэжилтэн Д.Энхбаяр